



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 507,473,048.70 (таван зуун долоон сая дөрвөн зуун далан гурван мянга дөчин найман төгрөг далан мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг автозам засвар, арчлалтын төрийн өмчит хувьцаат компаниудад балансаас балансад тус тус шилжүүлсүгэй.

2. "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ч.Золбаяр болон тогтоолд заасан автозам засвар, арчлалтын төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА



000280

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн  
03 дугаар тогтоолын хавсралт

"МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН  
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АВТОЗАМ ЗАСВАР АРЧЛАЛТЫН ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ  
КОМПАНИУДАД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт (км)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шилжүүлэх хуулийн этгээд	Шилжүүлэн авах хуулийн этгээд
1	Ниссан навара, 93-34УНЗ (арал-MNTCCVD40Z0006197)	6/9/2010	21500	42,423,360.00	42,423,360.00		Архангай аймаг дахь салбар	"Архангай-А33А" ТӨХК
2	Ниссан навара, 06-34 БӨТ, (арал-MNTCCVD40Z0006811)	8/5/2010	206697	42,423,360.00	42,423,360.00		Баян-Өлгий аймаг дахь салбар	"Сэлэнгэ-А33А" ТӨХК
3	Ниссан навара, 95-07 БНА, (арал-MNTCCUD40Z0004942)	2010-01-31	211953	42,155,481.45	42,155,481.45		Баянхонгор аймаг дахь салбар	"Өвөрхангай-А33А" ТӨХК
4	Ниссан навара, 59-01ДГА, (арал-MNTCCUD40Z0004927)	2010-01-31	134058	42,155,481.45	42,155,481.45		Дорноговь аймаг дахь салбар	"Дорноговь-А33А" ТӨХК
5	Ниссан навара, 54-08 ДУА, (арал-MNTCCUD40Z0006153)	2010-01-30	125979	42,423,360.00	42,423,360.00		Дундговь аймаг дахь салбар	"Төв-А33А" ТӨХК
6	Ниссан навара, 52-22ОРО, арал-MNTCCUD40Z0006236, гүйлт-221873	6/10/2010	221873	42,423,360.00	42,423,360.00		Орхон аймаг дахь салбар	"Орхон-А33А" ТӨХК
7	Ниссан навара, 93-64УНЗ, арал- MNTCCUD40Z0006201, гүйлт- 171985	6/10/2010	171985	42,423,360.00	42,423,360.00		Сүхбаатар аймаг дахь салбар	"Эрдэнэсант" ТӨХК
8	Ниссан навара, 28-02 УВА, (арал-MNTCCUD40Z0004945)	6/8/2010	138173	42,155,481.45	42,155,481.45		Увс аймаг дахь салбар	"Булган-А33А" ТӨХК
9	Ниссан навара, 47-04ХОА, (арал-MNTCCUD40Z0004946)	1/31/2010	146600	42,155,481.45	42,155,481.45		Ховд аймаг дахь салбар	"Налайх-А33А" ТӨХК
10	Ниссан навара, 63-02ХЭУ, (арал-MNTCCUD40Z0004926)	2010-01-31	187850	42,155,481.45	42,155,481.45		Хэнтий аймаг дахь салбар	"Харгуй-А33А" ТӨХК

11	Ниссан навара, 62-64ДАР, (арал-MNTCCUD40Z0004930)	2010-01-31	216332	42,155,481.45	42,155,481.45	Дархан-Уул аймаг Дахь салбар	"Дархан-АЗЗА" ТӨХК
12	Ниссан навара, 01-23БРА, (арал-MNTCCUD40Z0006155)	2010-01-31	147200	42,423,360.00	42,423,360.00	Багануур дүүрэг дэх салбар	"Багануур-АЗЗА" ТӨХК
	Нийт дүн			507,473,048.70 (таван зуун долоон сая дөрвөн зуун далан гурван мянга дөчин найман төгрөг далан мөнгө)	507,473,048.70 (таван зуун долоон сая дөрвөн зуун далан гурван мянга дөчин найман төгрөг далан мөнгө)		